

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/14-ШТА-ХОА

Ховд хот

2020 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Мөнхтулга

Утас: 7043-2545 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Утас: 7043-2545 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	5
ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь аудитын газар	Бүлэг 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ..	
Тэргүүлэх аудитор	1.1 Аймаг сумдын сонгуулийн зардлыг бодитой тооцжээ.	
Х.Болдбаатар	1.2 Аймгийн сонгуулийн хороо нь суманд олгох санхүүжилтийг холбогдох аргачлалын дагуу хуваарилжээ.	6
Утас	1.3 Төрийн захиргааны байгууллагын төсвийг бодитой төлөвлөсөн байна.	7
Аудитын менежер		
А.Цэцэгсүрэн		
Утас 99013699		
Аудитор		
Д.Мөнхтулга	Бүлэг 2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.	8
Утас:99031809	2.1 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.	8
Аудитор У.Батчимэг	2.2 Сонгуулийн хороод нь зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнажээ.	9
Утас:88094175	2.3 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажиллажээ.	9
2024 оны 07 дугаар сар		10
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ ҮҮ. www.audit.gov.mn		11
	Аудитын зөвлөмж	
	Тэргүүлэх Аудиторын тушаал	11
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.		11 12
ХАЯГ:		
Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар 3 давхар		

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийнэ.

Аудитын зорилт

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. .

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориуллын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Аймаг, сумдын сонгуулийн хороо, УБХ, аймгийн Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль:
- Төсвийн тухай хууль:
- Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль:
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль:
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль:
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль:
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгож

126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 2 тойрог, 17 сум, 91 баг, хороо, аймаг, сумын 17 сонгуулийн хороо, сумын сонгуулийн 93 хэсгийн хороо, мэдээлэл технологийн 5 багийн 105 ажилтан, нийт 105 даамал, улсын бүртгэлийн 93 итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 93 албан хаагч ажиллахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжих зардлыг аймгийн сонгуулийн хорооны 100160022001 дансаар дамжин зарцуулагдсан.

Аймгийн сонгуулийн хороонд 967.2 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 95.6 сая төгрөг, Цагдаагийн газарт 51.1 сая төгрөг нийт 1,114.0 сая төгрөгийг баталжээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг дараах байгууллагуудын дансаар дамжин зарцуулагдсан. Үүнд:

- Аймгийн сонгуулийн хороо
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Цагдаагийн газар

Бүлэг 1: УИХ-ын сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ.

Аймаг сумдын сонгуулийн хороодын зардлыг бодитой тооцжээ.

1.1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Ховд аймгийн Сонгуулийн хороог СЕХ-ны 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 23 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Аймгийн сонгуулийн хороо нь 17 сумдын сонгуулийн хороог 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01 тоот тогтоолоор 115 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд 17 сумын 93 хэсгийн хороотойгоор нийт 807 гишүүн мэдээлэл технологийн багт 5 гишүүн, мэдээлэл технологийн 111 даамал нийт 1047 төрийн албан хаагч аймгийн сонгуулийн хороонд ажилласан байна.


УИХ-ын 2-р тойрогт нийт 54,888 сонгогч бүртгэгдсэнээс 40,698 онгогч саналаа өгч 79.1 хувийн ирцтэй оролцжээ.

СЕХ-оос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороод, тэдгээрт ажиллах гишүүдийн тоо, хэрэгцээ шаардлагыг үндэслэн зардлыг тооцсон байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдад олгох санхүүжилтийг холбогдох аргачлалын дагуу хуваарилжээ.

1.2 УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 967.3 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 967.2 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 0.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт төвлөрүүлжээ.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа хүн амын тоо, газар нутгийн хэмжээг үндэслэжээ. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох зардлуудыг сумдын сонгуулийн хороонд хуваарилан ажиллажээ. Аймгийн сонгуулийн хороо нь нийт төсвийн 10.8 хувь буюу 104.2 сая, сумдын сонгуулийн хороодод 89.2 хувь буюу 863.1 сая төгрөгийг хуваарилжээ.



2020 оны УИХ-ын сонгуулиас сонгуулийн насны хүн амын тоо 545 нэмэгдэж санал өгсөн хүн амын тоо 2,418-аар буурчээ. 2024 онд Жаргалант Үенч сумуудад 2020 оны сонгуулийн хэсгийн хорооны тооноос тус тус 1 хэсгийн хороо нэмэгдсэн байна. Бусад сумдын хэсгийн хорооны тоонд өөрчлөлт ороогүй байна.

Төрийн захиргааны байгууллагын төсвийг бодитой төлөвлөсөн байна.

1.3 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст УБЕГ-аас 95.7 сая төгрөгийн санхүүжилт хуваарилж гүйцэтгэлээр 95.7 сая төгрөгийг зарцуулжээ. УБХ-ээс 2024 оны УИХ-ын сонгуульд 9 ажилтан ажиллаж итгэмжлэгдсэн болон гэрээт 95 ажилтан нийт 104 төрийн албан хаагч ажилласан байна.

Аймгийн цагдаагийн газарт ЦЕГ-аас 51.1 сая төгрөгийн санхүүжилт хуваарилж гүйцэтгэлээр 51.1 сая төгрөгийг зарцуулжээ. Цагдаагийн газраас УИХ-ын сонгууль зохион

байгуулахтай холбоотойгоор саналын хуудас хүргүүлэх үеийн хамгаалалтад 94, саналын хуудас, санал авах төхөөрөмж хадгалах байрны хамгаалалтад 17, санал авах байрны хамгаалалтад 93, гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлэхэд 32, сонгуулийн үйл ажиллагааны үед эргүүлд ажиллах 49, шуурхай удирдлагын штабд ажиллах 7, замын хөдөлгөөний зохицуулалтад 7 албан хаагч ажилласан байна.

Бүлэг 2: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Аймаг, сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2.1 Аймгийн сонгуулийн хороонд СЕХ-оос ирсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороонд 863.1 сая төгрөгийг хуваарилжээ. Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгээгүйгээр ажиллажээ. Сумдад олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Сонгуулийн хорооны нэрс	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
1	Алтай сумын сонгуулийн хороо	42.3	42.3	0
2	Булган сумын сонгуулийн хороо	51.2	51.2	0
3	Буянт сумын сонгуулийн хороо	46.7	46.7	0
4	Дарви сумын сонгуулийн хороо	48.9	48.9	0
5	Дуут сумын сонгуулийн хороо	34.8	34.8	0
6	Зэрэг сумын сонгуулийн хороо	47.1	47.1	0
7	Манхан сумын сонгуулийн хороо	56.3	56.3	0
8	Дөргөн сумын сонгуулийн хороо	40.2	40.2	0
9	Мянгад сумын сонгуулийн хороо	48.1	48.1	0
10	Мөнххайрхан сумын сонгуулийн хороо	35.3	35.3	0
11	Үенч сумын сонгуулийн хороо	58	58	0
12	Ховд сумын сонгуулийн хороо	48.1	48.1	0
13	Чандмань сумын сонгуулийн хороо	56.7	56.7	0
14	Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо	48.3	48.3	0
15	Жаргалант сумын сонгуулийн хороо	103.5	103.5	0
16	Мөст сумын сонгуулийн хороо	48.7	48.7	0
17	Цэцэг сумын сонгуулийн хороо	48.9	48.9	0
Нийт дүн		863.1	863.1	

Аймгийн сонгуулийн хороо нь 104.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж 0.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. унааны зардлыг 0.1 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

Батлагдсан төсвийн зарцуулалтыг хянахад дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

- Дуут сумын сонгуулийн хороо нь хоолны зардлаас хувь хүний орлогын албан татвар суутган авалгүй олгосон тул төлбөрийн акт бичлээ.


- Улсын төсвөөс

санхүүжүүлсэн хөрөнгөөр аймаг болон сумдын сонгуулийн хороо нь 9.2 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх бараа материал худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 16.2.5¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2² дахь заалтуудтай нийцээгүй байна.

¹ сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих

² Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

УБЕГ-аас аймгийн УБХ-т 95.7 сая төгрөгийн зардлыг хуваарилж гүйцэтгэлээр 95.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. УБЕГ-ын даргын 2024 оны А/24, А/104 тоот тушаалын



дагуу хуваарилагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

ЦЕГ-аас аймгийн цагдаагийн газарт 51.1 сая төгрөгийн төсвийг хуваарилжээ. Гүйцэтгэлээр 34.7 сая төгрөгийг хоолны зардалд, 14.4 сая төгрөгийг шуудан холбооны зардалд, 2.0 сая төгрөгийг шатахууны зардалд тус тус зарцуулжээ.

Сонгуулийн хороод нь зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнажээ.

2.2 Аймгийн 17 сумдын сонгуулийн хороо нь сонгуулийн хорооны гишүүнээрээ нягтлан бодогчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлжээ. СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар сумдын сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж аймгийн сонгуулийн хороон нэгтгэн тайлагнасан байна. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг харуулбал:

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	300.0	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	13,946.0	13,946.0	-
3	МТБ, даамлын сургалт	20,780.0	20,780.0	-
4	Бичиг хэргийн	14,710.0	14,710.0	-
5	Шуудан холбоо	17,500.0	17,500.0	-
6	Унаа	75,880.0	75,766.5	113.6
7	Санал авах байр бэлтгэх	28,830.0	28,830.0	-
8	Сурталчилгаа	8,000.0	8,000.0	-
9	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх, ачаа, томилолтын зардал	62,030.0	62,030.0	-
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	1,300.0	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	573,546.0	573,546.0	-
12	МТБ-ийн гишүүдийн урамшуулал, НДШ	71,456.0	71,456.0	-
13	Хоолны зардал	52,300.0	52,300.0	-
14	Томилолтын зардал	13,435.5	13,435.5	-
15	Шуурхай багийн зардал	2,130.0	2,130.0	-
16	Болзошгүй зардал	11,160.0	11,160.0	-
	НИЙТ ДҮН	967,303.5	967,190.0	113.6

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажиллажээ.

2.3 Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Ховд аймгийн 17 сумдаар ажиллаж сонгууль явуулахтай холбоотой хөрөнгийн зарцуулалт болон санал авах байранд ажиллах сертификат авсан төрийн жинхэнэ албан хаагчдыг хамарсан сургалт, арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгөн ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь 3 баг болж 17 сумдын 93 хэсгийн хороодод очиж хяналт шалгалтыг хийж ажиллажээ. Тус шалгалтаар жолоочийн тооцоо бодуулаагүй, санал авах байрны тохижилт дутуу хийгдсэн, хэсгийн хорооны гишүүд хороон дээрээ байгаагүй зэрэг дутагдал илэрснийг газар дээр нь засаж залруулан ажиллажээ.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн хорооны тайланг хүлээн авахдаа зөрүүтэй илэрхийлсэн алдааг хянаж залруулан авч дүнг үнэн зөв нэгтгэн гаргасан байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ.**
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.**

Аудитаар нийт 9.4 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 0.2 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт бичиж 9.2 сая төгрөгийн зөвлөмж бичигдлээ.

Аудитын дүнд илэрсэн зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн сонгуулийн хорооны дарга Б.Ганболдод

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд тусгуулан ажиллах.**

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ний дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

